



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №14


2019 оны 4 дүгээр сарын 22-26

### НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 291 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 75(25.8%) галзуугийн эрсдэлд өртсөн, 206(70.8%) хачигт халдвар, 4(1.4%) боом, 2(0.7%) хумхаа, 1(0.3%) ям, 2(0.7%) денги, 1(0.3%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.



#### 1.1 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 81 сум, нийслэлийн 6 дүүрэгт хачгаар дамжих халдварын 206 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 26.4%-иар буурсан байна. Эпидемиологийн 16 дугаар долоо хоногтой харьцуулахад 9 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



## 1.2 Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт нийт 75 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 36%-иар нэмэгдсэн байна. Эпидемиологийн 16 дугаар долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (38.7%), чононд (22.7%) үнэгэнд (10.7%), эзэнгүй нохойд (10.7%), үхэрт (5.3%), мануулд (4.0%), тэмээнд (1.3%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан.



### 1.3 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Дорнод аймгийн Хэрлэн сумаас боомын хүний өвчний сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдсэн. 2019 оны 4 дүгээр сарын 25-нд БОЭТ-ийн Халдвартын тасагт хэвтсэн байна. Одоогоор биеийн байдал тогтвортой. Дорнод аймгийн БОЭТ-д онош тодруулахаар нян судлалын лабораторит шинжилгээ хийгдэж байна. ЗӨСҮТ мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

#### Монгол улсад:

##### Галзуу өвчний мал, амьтны өвчлөл

Өвөрхангай аймгийн Тарагт сумын Арвайн тал багийн “Талын Овоо” гэдэг газар малчин “П”-ийн 1 үхэр 2019 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын захирамжаар 4 дүгээр сарын 23-нд 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон. Голомтонд нийт 361 мал амьтныг вакцинжуулсан байна.

Эх сурвалж: ОБЕГ

##### Галзуу өвчний мал, амьтны өвчлөл

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Мандал багийн “Дашийн Даваа” гэдэг газар малчин айлын 1 ямаа 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон байна. Голомтонд байгаа хот айлын 11 хүнд сургалт сурталчилгаа зохион байгуулан ажиллажээ.


Эх сурвалж: Хөвсгөл аймгийн ЗӨСТ

## ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

#### Олон улсад:

##### Эбола вирус халдвар:


2019 оны 4 дүгээр сарын 11-ний байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вирус халдварын сэжигтэй тохиолдол 1290 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 833 (65%) нь нас барсан. Нийт тохиолдлын 725 (56%) нь эмэгтэйчүүд, 361 (28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна.



Эх сурвалж: ДЭМБ


##### Гахайн сонгомол мялзан:

Япон улсын Мал амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Гифу хотын Яноцу дүүрэгт гахайн сонгомол мялзан өвчин бүртгэгдэж 1 гахайг устгасан байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна



**Шувууны томуугийн Ньюкасл өвчин:**

ОХУ-ын Мал амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Ставрополийн хязгаарт шувууны томуугийн Ньюкасл өвчний дэгдэлт бүртгэгдсэн байна. Нийт мэдрэмтгий 3 шувуу өртөмхий байснаас 1 шувуу өвчилж үхэн 2 шувууг устгасан байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.

**Африкийн гахайн мялзан:**

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өртөмхий байснаас	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	Румын Бузэу хот	2019.04.24	2019.04.22	Цэцэрлэгт хүрээлэнд		Гахай-1	Гахай-1
ДМАЭМБ	БНХАУ Хайнан	2019.04.24	2019.04.16	Тодорхойгүй	Гахай-7	Гахай-7	
ДМАЭМБ	Латви Rezeknes	2019.04.23	2019.04.16	Ойд			Гахай-1
ДМАЭМБ	Белги Люксембург	2019.04.23	2019.04.19	Ойд		Гахай-1	

Энэ долоо хоногт үйл явдлын мэдээгээ Баянхонгор, Баян-Өлгий, Дундговь, Төв, Ховд, Хөвсгөл, Говь-Алтай, Увс аймгууд мэдээгээ ирүүлсэн байна.